



Ахмад хилчний үг

2002 оны гуравдугаар сар.

Хил судлал сэтгүүлийн эрхлэгч
Г.Дагважамц Танаа

Доктор, профессор, хурандаа таны амрыг эрье.

Таны эрхэлсэн сэтгүүл, Монгол улсынхаа дархан хилийг судлах, сурталчилахад үлэмж хувь нэмэр оруулж буйд хөдөөгийн ард түмэн өндөр үнэлж байдагт би бахархдаг. Сэтгүүлийн редакцын хамт олонд алба, ажлын өндөр амжилт сайн сайхныг хүсэн ерөөе.

Таныг гүнээ хүндэтгэн ёслов.

*Хөвсгөл аймаг дахь ХЦ-ийн
0257 дугаар ангийн ахмад хилчин,
чөлөөнд буй хошууч Норовлонгийн Чойжоон Авран*

Өнөөдөр анхаарах чухал асуудал

Өнгөрсөн зууны 80-аад оны үеэс дэлхийн 230 гаруй улс орнуудын харилцаа нь зэргэлдээх улс орнуудын хүрээнээс хальж, тив, бүс хоорондын улмаар дэлхийг хамарсан шинжтэй болсон...

Энэ нь олон улсын гадаад харилцаа өвөрмөц бүтэц, зүй тогтолтой системд хүргэсэн гэж хэлмээр байна. Энэ системийг дэлхийн хамтын нийгэмлэгт бүхэлд нь хамаарах даяарчлал хэмээх үйл явц бий боллоо гэж үзсэн болой. Даяарчлалын сайн үр дагаврын нөлөөгөөр дэлхийд ардчилсан "Их хувьсгал" болсноор социалист систем задарч, нийгмийн социалист хэлбэршил капиталист хэлбэршилд ухран шилжих процесст олон улсын нийтлэг нэг хэв

шинж бүхий капиталист дэг жаягийг даган нийтлэг зорилго чиглэлийг сонгох болсноор олон улсын харилцааны бүтэц, хил хязгаарын хамгаалалтанд өвөрмөц асуудлыг бий болгосон.

Энэ нь улсын хил хамгаалах гэдэг нь дан ганц хил хамгаалсан Хилийн цэргийн буюу нэг улс орны асуудал биш олон орнуудын хамтын асуудал болох нь тодорхой боллоо. 2001 оны 9 дүгээр сард АНУ □ д халдсан террорист дайралт олон улсын хил хязгаар дамнасан түрэмгий ажиллагаа учир Афганистаны хилийг хамгаалж ард түмний амгалан байдал тогтооход АНУ, ХБНГУ, Франц, ОХУ гэх мэт улс орнууд тусалж буйгаас тодорхой. Даяарчлалын үед улсын хил хамгаалалт нь нэг орны ард түмний эрх ашгийг хүндэтгэн үзэх, тэр улс орныхоо хилийг дархан амгалан байлгахад найрамдалт гэрээ, хэлэлцээртэй улс орнууд хамтарч хамгаалах үйл явцыг бий болгоход нөлөөлжээ.

Капитализм дангаараа ноёрхсон өнөө үед даяарчлал нь дархан хилтэй, өөрийн эх орноо хайрласан ард түмнүүдийн харилцаанд нэг хэв маягаас зайлсхийхийг үйл явц өөрөө шаардах болжээ. Тэгэхдээ даяарчлалын гол үүргийг капиталист төр гүйцэтгэхийг олон улсууд хүлээн зөвшөөрч буй нь учиртай. Яагаад гэвэл өнөөдөр дэлхийг нэгдмэл нэг бүхэл гэж ойлгож эхэлсэн нь 20-р зууны сүүлчээс дэлхийн эдийн засаг, аж ахуй, соёл интеграцчиллын хөгжлийг ухаарсантай холбоотой. Энэ нь ч дэлхийн экологи, хүнс, хүн амзүй, боловсрол, эрүүл мэнд, түүхий эдийн нөөц бүхий газар нутгаа хамгаалах зэргийг хүн төрөлхтөний оршихтой холбон олон улсын хэмжээнд шийдэх өргөн бололцоог даяарчлал бүрдүүлж өгсөн билээ. Монгол улс “Их хувьсгалын” арван хоёр жилд капитализмын зах зээлийн эдийн засгийн зурвас үеийг, дэлхийн даяарчлах үйл явцтай давхацуулан хослон явуулж буй нь өвөрмөц онцлог юм.

Даяарчлал манай улсын дархан хилээ хамгаалахад сайнаар нөлөөлсөөр байгаа нь:

- ОХУ, Хятад болон бусад дэлхийн улсуудтай улсын хилээ хамгаалах талаар гэрээ, хэлэлцээр, уулзалт хийх
- Тэргүүний зэвсэг, техник, технологи нэвтрүүлэх
- Сансарын мэдээ, мэдээлэл солилцох, нарийн мэргэжилд хүмүүсээ харилцан сургах

ХИЛ СУДЛАЛ

- Олон улсын террорист түрэмгий халдлагаас улсын хилээ хамтран хамгаалах

- Байгалийн гамшиг гэнэтийн аюулаас улсын хилийг урьдчилан сэргийлэх

- Олон улсын дархан хил зөрчсөн мафийн бүлэглэл, хар тамхины наймаа, хүн барьцаалах, онгоц хулгайлан олон улсын хил дамнасан гэмт учралыг таслан зогсооход харилцан ажиллах

- Улсын хилийн зөрчлийн шалтган нөхцөлийг нарийн судлахад шинжлэх ухаан техникийн болон практик дадлагаа хөгжүүлэх зэрэг өргөн боломжуудыг бодит байдал болгоход туслаж байна.

Гэвч даяарчлал улсын хил хамгаалатанд нөлөөлөх сөрөг үр дагавар буйг үгүйсгэх аргагүй юм. Үүнд:

- Хил зөрчигчид онош нь үл мэдэгдэх өвчин авчирах,

- Спирт, мансууруулах бодис, химийн бодис оруулах,

- Баталгаагүй эм, хүнсний бүтээгдэхүүн нэвтрэх,

- Түүхийн дурсгалт, соёл урлагийн бүтээлүүд, хориотой ангийн арьс, бугын эвэр, согооны сүүл, хүдэрийн заар, алт мөнгөн эдлэл гаргах,

- Зэвсэглэсэн хулгайчид, мал, ан амьтанг хилээр гаргах (амьдаар нь),

- Спирт, тарваганы арьс, машин, адууг улсын хилээр хууль бусаар гаргахад жижиг мафийн бүлэглэл буй нь ч мэдэгдэж байгаа зэрэг олон бусармаг үйлдлүүд бий болж ариун дархан хилээ хамгаалж байгаа хилчдийн маань арга ажиллагааг улам хүндрүүлж байгаагаас гадна хилчдээс хил хамгаалах урлагаа хөгжүүлж, нарийн арга, тактик боловсруулан, тэмцэхийг шаардах болжээ.

Иймд ч 2002 онд ХХЕГ-аас хөгжүүлэх асуудлыг нэгдүгээрт тавьж, хоёрдугаарт бүх ажил үйлсээ хил хамгаалалтын нэгж, харуулд төвлөрүүлэх, гуравдугаарт ахуй нөхцөл, орлогын чадвартай байх гэсэн зориулалтууд дэвшүүлсэн билээ.

Хил хамгаалахад сэтгэлзүйн урлаг хөгжиж буй өнөө үед хилийн цэргийн анги салбарт гарч буй зөрчил, учралын шалтгааныг арилгах нь чухал юм. Үүнд:

Нэгдэх шалтгаан: хавар намартаа ирээд, хавар намартаа буцдаг отрын малчин шиг отрядын цэрэг сэтгэлзүйн төлөвшилгүй, бичиг үсэг мэддэггүй, эрүүл мэнд муу бодгаль хүн алба хаахаар цэргийн эрдэм сурч чадахгүй бэрхшээж хүний амь бүрэлгэх, сахилга дэг журам, хэрэг зөрчил гаргаж буй нь хил хамгаалах байгууллагын салбарын буруу биш ээ. Иймд хилийн цэрэг нэн богино хугацаанд хилийн цэргийн дээд сургуульд улирсан ахлагч нарыг байнгын хил хамгаалагчдаар сургаж, хойд хилийг дан улирсан, мэргэжил дадлагатай төлөвшсөн ёс суртахууны өндөр чадвартай хилчдийг тавих нь хайран мөнгө гарздахаас илүү өгөөжтэй буйг тооцоолоход тодорхой юм.

Хоёрдох шалтгаан: өнөөгийн нийгмийн гаж нөлөөллөөс болж байна. Хүний бүх амьдрал мөнгө, хувийн өмч хоёр дээр тулгуурлан хүн бүхэн баяжихын төлөө хүн алах, дээрэм хийх, мөнгөтэй л бол санаснаа хийж болдог анархизм хэт дэлгэрснээр арван жилийн эхнээс захирах, захирагдах ёс зарчмыг үл ойлшоогч цэргүүдийг энэ нийгэм буй болгосон юм. Тийм ч учрас хил хамгаалах ерөнхий газрын буруу байхгүй бөлгөө.

Гуравдахь шалтгаан: даяарчлалын сөрөг үр дагаврын зарим нөлөөгөөр өнгөрсөн зууны сүүлчээр согтуу Монгол нэр зүүж, нийслэл Улаанбаатар олон улсын зарлалын самбар болж нэг хэсэг хугацаанд спирт, согтууруулах ундаа хилээр оруулж ирэхэд том дарга нар холбогдох, зарим нэг хил зөрчиж гэмт хэрэг учрал гаргасан этгээдүүд хилийн чанадад оргонох зарим зэвсэглэсэн хулгайч дээрэмчид Монгол Тувагийн хилд мал, ан амьтныг олон тоогоор амьдаар нь хулгайлан ард иргэдийн амь бие, эрх чөлөөнд халдсан зэрэг нь дээрхийн уршиг юм.

Үүнийг арилгахад спирт, мансууруулах бодис оруулахыг тас хориглох, мал, адгуусан амьтдыг хилээр хууль бусаар хулгайлан нэвтрүүлсэн этгээдэд оногдох ял зэмлэлийг чангатгах, тарваганы арьс боловсруулдаг (ер нь ангийн арьс) үйлдвэрийг монголдоо байгуулах зэргийг засгийн газар анхааралдаа авна байх.

Их хэмжээний спирт, мансууруулах бодис, хар тамхи, хориотой эм, буу зэвсэг, мафи, террорист харгис бүлэглэл зэвсэглэсэн хулгайчид зэргийн үйл ажиллагааг үйлдлээ эхлэхээс өмнө урьдчилан

ХИЛ СУДЛАЛ

сэргийлэх арга хэмжээ авахад хууль хяналтын болон тагнуулын байгууллага анхаарна гэдэгт бүрэн итгэдэг билээ. Хил хамгаалх ерөнхий газраас 2002 онд хүнээ хөгжүүлэх талаар дэвшүүлэн тавьсан зорилтыг хэрэгжүүлэх талаар хилийн цэргийн анги салбар, харуулын байранд ёс суртахуун сэтгэл зүйн хангалтын талаар юуг хийж ажиллавал зохих вэ гэвэл хүнээ судлахаас эхлэх нь чухал. Үүнд:

- Дарга үүрэг тушаал өгөөд судлах арга
- Хөдөлмөр хийлгэх арга (ажилд томилох)
- Анкет бичүүлэн төрөл садангаас нь лавлагаа авах
- Ажиглаж хяналт тавьж судлах гээд олон арга байдаг. Энэ аргуудаас эхний хоёр арга нь дэвшилттэй гэж үзэж байна.

Жишээ нь: даргаас үүрэг тушаал авсан хүн чанартай хугацаанд нь биелүүлээд илтгэвэл сайн бөгөөд тушаалыг нь хагас дутуу биелүүлээд хугацаа хожимдуулдаг бол үнэнч шударга бус болохоо харуулж байх жишээтэй. Ажил хөдөлмөрөөр шалгах арга нь хүний чанарыг үнэхээр харуулна. Ажилд идэвхи санаачлага хариуцлагатай хүн даргын зааж өгсөн ажлыг чанартай хийнэ. Хариуцлагагүй хүн ажлыг оронцлоглодог.

Сонгож авсан хүнтэйгээ дарга нар ажиллаж тэднийг өв тэгш хүмүүжүүлж, хөгжүүлнэ гэдэг нь: нэгдүгээрт мэдлэг боловсролын нь түвшинг дээшлүүлэх, хоёрдугаарт авъяас чадварыг нь хөгжүүлэх, гуравдугаарт ажил мэргэжлийн дадлага туршлагатай болгох, дөрөвдүгээрт сэтгэлзүй, ёс суртахууны хүмүүжил төлөвшүүлэх, тавдугаарт шинжлэх ухаан техник технологи, хэлний мэдлэг олгох зэрэг олон талт ажлууд зохиох ёстой.

Иймд:

1. Хилийн отряд ангиас зохиох ёс суртахуун сэтгэл зүйн хангалтын ажил нь:

- Ажил мэргэжлийн уралдаан, тэмцээн, мэтгэлцээн явуулах
- Мэргэжлийн албаны дамжаанд ээлж дараагаар сургах
- Явуулын номын сан, эмийн сан, хэвлэлийн фонд ажиллуулах
- Бичмэл сэтгүүл, гарын лавлагаа материал гаргах
- Лекц яриа, аман ухуулга хийх аргачлал гаргаж өгөх

- Нээлттэй хичээл, өргөтгөсөн семинар, зөвлөлгөөн зохиох
- Уулзалт, үдэшлэг, шоу, заставуудын урлаг соёлын өдөрлөг явуулах

- Хөгжмийн хамтлаг бүхий авъяастнуудын чуулгын хэсэгтэй болон заставуудаар үйлчлэх

- Спортын бүлгэм дугуйлан ажиллуулах
- Орон нутгийн төрийн бус ОНБ-уудтай хамтран ажиллах
- Гадаад хэлний дамжаа хичээллүүлэх
- Шинэ техник, технологийн сургалт явуулах зэрэг болно.

2. Хилийн сумангуудад зохиох ёс суртахуун сэтгэл зүйн хангалтын ажил нь:

- Нарны эх үүсвэрийн тусламжтай радио, телевизын хөтөлбөр үзүүлэх

- Олон улсын болон цаг үеийн мэдээ мэдээлэл сурталчлах, ухуулагчийг томилон ажиллуулах

- Гадаад хэл сурах дамжааны нэг өдөр сонгон хичээллэх

- Ном хэвлэл захиалах, улсын хил хамгаалахтай холбогдсон сэдвээр ярилцлага зохиох

- Албан хаагчид гэр бүлийн хамтарсан зөвлөлгөөн хийх

- Шинэ техник, технологийн сургалт явуулах

- Ахмад дайчид удирдах дарга нартай уулзалт зохиох

- Орон нутагт багийн өдөрлөг дээр хилээ, байгууллагаа сурталчилсан хамтарсан ажил зохиох

- Сумангийн спорт урлагын ба ажил мэргэжлийн аврага шалгаруулах

- Хилийн туслах хүчнүүдтэйгээ хамтарсан сургалт зохион байгуулах гэх мэт...

3. Харуулын байранд зохиох ажлууд нь:

- Ажил төрлийн шуурхай зөвлөлгөөн хийлгэх

- Хилийн цагийн байдлын мэдээ мэдээлэл өгөх

- "Мэдлэгийн сан", "нэвтэрхий толь" зэрэг хичээл сургуульд туслах материалуудын цомог гаргах

- Хилчдийн заавал мэдсэн байх зүйлсийн жагсаалт бүхий самбар, үзүүлэн гаргах

- Ном хэвлэлийн лавлах булантай байлгах

ХИЛ СУДЛАЛ

- Батерейн радио, өврийн радио сонсголтой болгох
- Спорт биеийн тамирын дасгал, гимнастик төрөл бүрийн нормативыг шалгаруулах тэмцээн зохиох зэрэг олон төрлийн ажлуудыг ёс суртахуун сэтгэл зүйн хангалтын албанаас зохиохын хамт нөгөө талаас бие хүн өөрөө өөрийгөө хөгжүүлэх талаар идэвхитэй шамдаж ажиллах нь ХХЕГ-аас дэвшүүлсэн хүнээ хөгжүүлэх зорилтыг хэрэгжүүлэхэд гол үүрэг гүйцэтгэх болно.

Үүнд бие хүн “хилчин” өөрөө өөрийгөө хөгжүүлэхэд биеэ дааж дараах ажлыг хийх хэрэгтэй. Үүнд:

- Хичээл сургуулилтанд бүрэн оролцож амжилттай суралцах
- Мэдлэгээ дээшлүүлэхэд байнга хичээж, ном хэвлэл ашиглах
- Хувийн номын сан, архиваа арвижуулах
- Гадаад хэл бие дааж сурах
- Зэвсэг техник технологийн шинчлэлээс хоцрохгүй байх
- Өөрийн авъяас чадвараа дээшлүүлэхэд саначлага гарган удирдлагаас дэмжлэг авах
- Биеийн эрүүл мэндээ хамгаалах, спортын сонирхсон төрлөөрөө хичээллэх
- Эрхэлсэн ажил албандаа бэлтгэхэд идэвхи санаачлага гарган ажиллах
- Гэр бүл, үр хүүхэд, найз нартаа цаг ямагт тусалж, тэдний хүмүүжил ёс суртахуунд биеэрээ үлгэр жишээ үзүүлэх зэргээр ажиллах нь өмнөх зорилтоо биелүүлж бүрэн төлөвшсөн хилчин болж, Монгол Улсынхаа мөнхөд орших дархан хилийн соргог манаа байсаар байх болно.

Хилийн тэнгэр цэлмэг байх болтугай.

*Бэлтгэл хошууч Норовлонгийн
Чойжсоон Аврон*